



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/377

Булган сум

**Хэлний бодлогын салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий “Хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. “Хэлний бодлогын салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2025 оны А/115 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 22-ны/ний өдрийн
А/ЗТТ дугаар захирамжийн хавсралт



ХЭЛНИЙ БОДЛОГЫН ОРОН ТООНЫ БУС
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн
захиргаа, удирдлагын хэлтсийн дарга
Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх
зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга
Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга
Насан туршийн суралцахуйн төвийн захирал
Боловсролын газрын Монгол хэл, уран зохиолын
боловсрол хариуцсан ахлах арга зүйч
Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэл,
уран зохиолын багш нарын төлөөлөл- 3
Ахмад багш нарын төлөөлөл-2
Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн Боловсролын бодлого,
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

--o00o--